

МОНИНЖБАР ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2015 оны 04 сарын 17

Улаанбаатар хот

Эрхэм хувь нийлүүлэгчидээ!

Эрхэм Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээ!

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэхийн ялдамд компанийн гүйцэтгэх удирдлагыг дэмжин ажилладагт талархал илэрхийлж байгааг хүлээн авна уу.

2014 оныг компанийн гүйцэтгэх удирдлагын зүгээс “Их бүтээн байгуулалт”-ын жил болгон зарласан нь үр дүнгээ өгч борлуулалтын болон гүйцэтгэсэн барилга угсралтын ажлын хувьд урьд онуудаас давсан үзүүлэлттэй жил болон өнгөрлөө.

2014 онд улсын төсөв болон Азийн хөгжлийн банк, төсөл хөтөлбөрүүдээс зарласан 20 гаруй тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий тендер шалгаруулалтанд оролцсоноос 9,4 тэрбум төгрөгийн сонгон шалгаруулалтанд ялж 6.6 тэрбум төгрөгийн борлуулалт бүхий барилга угсралтын ажлыг гүйцэтгэлээ.

- 2014 онд шинээр гэрээ байгуулж гүйцэтгэсэн барилга угсралтын ажлын талаар тэдм танилцуулахад:
 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэн “Эрчим хүчний яамны захиалгаар” 5в магистраль Тк-1893-с Континенталь зочид буудлын баруун талын уулзвар хүртэлх 2800м Ф500мм-н шугамыг Ф800мм болгон өргөтгөх” ажлыг 5,385 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр барьж гүйцэтгэхээр 2014 оны 04 сарын 28-ны өдөр ЭХА-018/14 тоот гэрээг байгуулж барилга угсралтын ажлыг 2014 оны 05 сарын 07-ноос 2014 оны 09 сарын 15-ны хооронд гүйцэтгэлээ. Тус ажлыг гүйцэтгэхэд зөвлөх болон мэргэжлийн инженер 8, үндсэн мэргэжлийн 20 гаруй ажилчин, 30 гаруй туслах ажилчинтайгаар 15 машин механизм ашиглан цаг хугацаанд нь чанарын өндөр түвшинд хөдөлмөр, аюулгүй ажиллагааны норм, нормативыг барьж ажилласан. Уг гэрээт ажлын төсөвт өртөг нь 5,385 тэрбум төгрөг боловч 2014 онд 2,52 тэрбум, 2015 онд үлдэгдэл 2,865 тэрбум төгрөгийг улсын төсвөөр санхүүжүүлэхээр тусгагдсан байсан. 2014-2015 онд үүсч байгаа санхүү эдийн засгийн хямралаас шалтгаалж улсын төсвийн орлого бүрдүүлэлт тасалдсаны улмаас 2015 онд санхүүжих 2,865 тэрбум төгрөгийн 50 хувь буюу 1,432 тэрбум төгрөгийг 2015 ондоо багтаан улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр Монгол улсын Хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр 2015 оны улсын төсвийн тодотголоор санхүүжүүлэхээр батлагдсан боловч өнөөг хүртэл шийдвэрлээгүй байна. Тухайн ажлыг гүйцэтгэхэд бид харилцагч Хаан банкнаас 1,480 сая төгрөгийн зээлийг 1 жилийн хугацаатай сарын 1,45 хувийн хүүтэйгээр авсан бөгөөд зээлийн хугацаа 2015 оны 07 сард дуусахаар байна.
 2. Азийн хөгжлийн банк болон Монгол улсын төсвийн хөрөнгө оруулалтаар /49 хувь нь АХБ, 51 хувь нь улсын төсөв/ хөрөнгө оруулалтаар Өмнөговь, Дорноговь аймгийн хил орчмын суурин газрын дэд бүтэц хөгжүүлэх төслөөс зарласан Өмнөговь аймаг Цогтцэций сумын төвийн ус хангамж, ариутгах татуургын шугам, усан сан, бохир усны насос станц, ус түгээх байр, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх сонгон шалгаруулалтанд ялж 2014 оны 05 сарын 27-нд 1,1 сая ам долларын өртөг бүхий G0204-MON тоот гэрээг байгуулсан. Уг гэрээт ажлыг 2014 оны 05 сарын 27-ноос 2014 оны 12 сарын 25-ныг хүртэл барилга угсралтын ажлыг 95 хувьтай гүйцэтгэн техникийн комисс ажиллуулж 2015 оны 06 сарын 01-нийг хүртэл улсын комисс ажиллуулах хүртэлх хугацаагаар гэрээг сунгасан. Барилга угсралтын гэрээг сунгасан шалтгаан нь гүйцэтгэгчээс шалтгаалаагүй бөгөөд зураг төсөвт өөрчлөлт орж сумыг ундны

усаар хангахад одоо ашиглагдаж байгаа Ухаа худаг-Ус хангамж ХХК-ийн шугамаас огтолгоо авахаар шийдвэрлэж шинээр техникийн нөхцөл авах шаардлагатай болсон. Мөн бохир усны насос станцаас Энержи ресурс ХХК-ийн цэвэрлэх байгууламжтай холбогдох холболтын техникийн нөхцөл авах шаардлагатай болсон бөгөөд эдгээр техник нөхцөлүүд нь 2014 оны 12 сарын 25-нд гарсан тул өвлийн улиралд шугам сүлжээний холболт хийх бололцоогүй технологийн горим зөрчигдөхөөр байсан тул эдгээр үлдэгдэл холболтын ажлыг 2015 оны 05 сард гүйцэтгэн 06 сарын 01-ны дотор улсын комисст хүлээлгэн өгөхөөр гэрээ сунгагдсан. Хэдийгээр барилга угсралтын ажлын 95 хувийг гүйцэтгэсэн боловч улсын төсвийн орлого бүрдүүлэлтээс шалтгаалж улсын төсвөөс санхүүжигдэх хөрөнгө оруулалт тасалдаж 2014 онд ямарч санхүүжилт хийгдээгүй. Тухайн ажлыг гүйцэтгэхэд Азийн хөгжлийн банкны санхүүжилтийг бүрэн авч нэмж банк бус санхүүгийн байгууллагаас 300 сая төгрөгийн зээлийн эх үүсвэрээр гүйцэтгэсэн.

3. Төрийн орон сууц корпорацийн санхүүжилттэйгээр Хэнтий аймаг Хэрлэн сум 3-р баг “Тэмүүжин хороолол” 62 айлын тохилог амины орон сууцны гадна инженерийн шугам сүлжээний ажлыг 1,670,167,536 төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр гүйцэтгэхээр 2014 оны 09 сарын 05-ны өдөр гэрээ байгуулж 2014 оны 09 сарын 10-ны өдрөөс 2014 оны 11 сарын 27-нийг хүртэл 100 хувь гүйцэтгэн улсын комисс ажиллуулж байнгын ашиглалтанд хүлээлгэн өглөө. Тухайн ажлын хүрээнд төмөр бетон сувагчлал бүхий дулаалгатай цэвэр болон дулааны 1400м, бохир усны 1640м шугамын ажлыг инженер техникийн 3, мэргэжлийн болон туслах 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй 6 машин механизм ашиглан гүйцэтгэсэн. Уг ажлын санхүүжилт нь 2014 онд 100 хувь санхүүжигдсэн.
- Урд онуудад барилга угсралтын ажлыг гүйцэтгэн техникийн болон улсын комисс ажилласан боловч зураг төсөв, хэрэглэгчгүй, ашиглагч байгууллага тодорхойгүй гэсэн шалтгаануудын улмаас хүлээж авахгүй байсан дараах ажлуудыг засвар үйлчилгээний нэмэлт зардлуудыг гаргаж хүлээлгэн өглөө. Үүнд:
 1. Баянзүрх дүүргийн 2-р хороо, Дарь-Эхийн амины орон сууцны хорооллын гадна цэвэр, бохир усны шугамын барилга угсралтын ажлыг 2008-2009 онуудад гүйцэтгэж улсын комисс ажиллуулсан боловч ашиглагч байгууллага болох Ус сувгийн удирдах газар хэрэглэгч байхгүй, тухайн ажил нь Азийн хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээр санхүүжигдсэн учраас зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийг хариуцах байгууллага байхгүй гэсэн шалтгаанаар хүлээж авахгүй 2014 он хүргэсэн. 2014 оны 10 сард Улаанбаатар хотын удирдлага болон Ус сувгийн удирдах газар хамтран шийдвэрт хүрч уг төслийг хүлээн авлаа.
 2. Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг Дамбадаржаагийн орчмын амины орон сууцны хорооллын гадна цэвэр, бохир усны шугамын ажлыг 2012 онд 100 хувь гүйцэтгэн бүрэн ашиглалтанд оруулсан боловч Азийн хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээр санхүүжигдсэний улмаас мөн дээрхи шалтгаанаар улсын комисс ажиллуулахгүй хүлээгдэж байсан. Уг ажлыг 2014 оны 06 сард улсын комисс ажиллуулан хүлээлгэн өглөө.
 3. Монгол улсын Хөгжлийн банкны санхүүжилтээр Баянголын амны орон сууцны хорооллын дулааны шугамын өргөх насос станцын барилга угсралтын ажлыг 2013-2014 онд 3,45 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр 2013 оны 07 сарын 16-нд гэрээ байгуулж барилга угсралтын ажлын 95 хувийг гүйцэтгэн техникийн комисс ажиллууллаа. Уг гэрээт ажлыг гүйцэтгэгч компани 100 хувь гүйцэтгэн улсын комисс ажиллуулахад бэлэн байгаа боловч гүйцэтгэгчээс шалтгаалахгүйгээр дараах хүндрэлүүд үүсч Эрчим хүчний яам, төслийн нэгж, гүйцэтгэгчид 3 талт гэрээ байгуулан улсын

комисс ажиллан байнгын ашиглалтанд оруултал харуул хамгаалалтыг гүйцэтгэгч компани хариуцахаар царцаалаа. Үүнд:

- Ашиглагч байгууллага өнөөг хүртэл тодорхой бус
- Насос станц руу очиж байгаа дулааны дамжуулах шугам үерт автаж энэ хэвээр ашиглах боломжгүй болсон.
- Дулааны шугамыг хэрэглэх хэрэглэгч одоогоор байхгүй.

4. Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн Ногоон зоорь орчмын орон сууцны хорооллын гадна цэвэр усан хангамж, усан сан, насос станцын барилга угсралтын 2-р ээлжийн ажлыг 1,12 тэрбум төгрөгийн санхүүжилттэйгээр 2013-2014 онуудад гүйцэтгэхээр гэрээ байгуулж ажиллаа. 2013 онд төсөвт тусгагдсан цэвэр усны шугамын ажлыг 100 хувь, 2014 онд насос станцын барилга болон усан сангийн ажлыг 70 хувьтай гүйцэтгэлээ. Уг ажлыг гүйцэтгэхэд зураг зохиогчоос гаргасан зураг төсөл дутуу, техникийн нөхцөлүүд гараагүй, насос станц болон усан санг тэжээх цэвэр усны шугам, цахилгааны эх үүсвэр байхгүй, насос станцын доторхи тоноглол, тоног төхөөрөмж төсөвт өртөгт тусгагдаагүйн учраас хийгдэх боломжгүй болсон. Эдгээр шалтгаануудын улмаас усан сан болон насос станцын туршилт тохируулгыг хийх боломжгүй болж 2015 оны нийслэлийн төсөвт шаардлагатай нэмэлт хөрөнгийг тусгаж барилга угсралтын ажлыг гүйцэтгэсний дараа үлдэгдэл ажлыг гүйцэтгэн хүлээлгэн өгөхөөр харилцан тохиролцлоо.

Гүйцэтгэсэн барилга угсралтын ажлаас харахад компани 2014 оны төлөвлөгөөг хангалттай биелүүлсэн гэж үзэж байна. Мөн 2014 онд хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны болон барилга угсралтын гүйцэтгэлтэй холбоотой доголдол, дутагдал, аваар осол гаргалгүй ажиллалаа. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа болон ажлын байрны нөхцөлийг сайжруулахад 74 сая төгрөгийг зарцуулсан байна.

- **Удирдлага, бүтэц, зохион байгуулалтын талаар**

Компани 2014 онд 200 гаруй ажиллагсадтай үйл ажиллагаа явуулсанаас инженер 20, 50 орчим техникийн болон мэргэжлийн ажилчид, 100 гаруй туслах ажилчинтай 8 объектод барилга угсралтын ажлыг гүйцэтгэлээ. 2014 онд залуу инженер, техникийн ажилчид шинэ барилга угсралтын ажлыг хариуцан ажиллаж өөрсдийн мэдлэг боловсрол, удирдан зохион байгуулах чадвараа хамт олондоо харуулж чадлаа. Инженер, менежерүүдийн ажилдаа идэвх зүтгэлтэй, сайн зохион байгуулалтын үрээр гэрээт ажлуудыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж ашиглалтанд орууллаа. Ажил гүйцэтгэх явцад урамшууллын олон янзын хэлбэрийг хэрэглэж үүнд 60 орчим сая төгрөгийг зарцуулсан байна. Мөн одоо ажиллаж байгаа инженер, техникийн ажилчид, менежерүүдийг ажилдаа тогтвор сууршилтай ажиллах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зориулж орон гэр авах, албан ажил болон хувьд унах зорилготой унаа авахад зориулж 40 сая төгрөгийн дэмжлэг, 50 гаруй сая төгрөгийн тодорхой хугацаатай зээлийг олгож хугацаандаа төлөгдөж байна. Компанийн гүйцэтгэх удирдлага 2014 оноос эхлэн хавсралт 1-д заагдсан бүтэц зохион байгуулалттайгаар ажиллаж байна.

- **Сургалт, мэргэжил дээшлүүлэх, нийгмийн ажлын талаар**

Өнгөрсөн жил бидний хувьд ахмад инженер техникийн ажилчдынхаа мэргэжлийн ур чадвар, туршлага дээр тулгуурлан залуу боловсон хүчин, инженерүүдийг ажлын байраар хангаж, тэднийг ажилдаа идэвх санаачлагатай, мэргэжлийн ур чадвар гарган ажиллахад ихээхэн дэмжлэг тусалцаа үзүүлэн инженерүүдийг ажлын байраар хангаж, тэднийг ажилдаа идэвх санаачлагатай, мэргэжлийн ур чадвар гарган ажиллахад ихээхэн дэмжлэг тусалцаа үзүүлэн ажиллалаа. Тэднийг мэргэжилдээ эзэн болоход бүхий л нөөц бололцоогоор хангаж ажилласан ба барилгын салбарт боловсон хүчин бэлддэг их, дээд сургуулиудтай хамтран ажиллаж тэдний мэргэжлийг дээшлүүлэхээр /магистрийн сургалт/ 2 инженерийн сургалтын төлбөрийг хариуцан сурч байх хугацаандаа болон цаашид үргэлжлүүлэн ажиллахаар гэрээ байгууллаа. Мөн компанийн

ахмад, туршлага бүхий инженерүүд зөвлөх болон мэргэшсэн инженерийн шалгалтуудыг амжилттай өглөө.

- **Шагнал урамшуулал**

2014 онд компанийг Монгол улсын их бүтээн байгуулалтанд мэргэжлийн боловсон хүчин, машин механизм, тоног төхөөрөмжийг ашиглан мэдлэг чадвар, бүхий л нөөц бололцоогоо дайчлан ажилласныг үнэлж Барилга хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төв, Барилгачдын холбооноос 2014 оны барилгын салбарын “Нийгэм ахуйн барилга байгууламжийн угсралтын шилдэг компани”-аар, Гүйцэтгэх захирал Б.Баярсайханыг “Шилдэг удирдагч”-аар өргөмжилсөн. Мөн салбарын “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр 3 ажилтаныг, Яамны жуух бичгээр 5 ажилтаныг шагнаж урамшууллаа.

- **Техник, технологийн шинэчлэл**

Компани тухайн тайлант жилд барилга угсралтын ажилд шаардлагатай байгаа HYUNDAI 220 маркийн 1.3м3 багтаамжтай дугуйт эксковатор 1, LIBNIEP 920 маркийн гинжит 1,3м3 багтаамжтай шанагат эксковатор 1 ширхэгийг санхүүгийн лизингийн нөхцөлөөр худалдан авч авто баазыг өргөжүүллээ. Мөн ашиглалтын хугацаа дууссан ажлын бүтээмж багатай зарим техник тоног төхөөрөмжүүдийг актлан тодорхой үнээр зах зээлд борлуулан хуримтлагдсан хөрөнгөөр 50 гаруй сая төгрөгийн засвар үйлчилгээг хийж гүйцэтгэн техникийн насжилтыг уртасгалаа.

Энэ бүгдээс дүгнэн хэлэхэд компанийн гүйцэтгэх удирдлага хэдийгээр 2013 оны сүүл 2014 онд Монгол улсад эдийн засгийн хямралтай, гадаад валютын ханш 40 орчим хувиар өсөж, гүйцэтгэсэн барилга угсралтын ажлын санхүүжилтүүд удаан хугацаагаар саатаж тасалдаж байсан боловч компани энэ бүгдийг даван туулахын тулд тодорхой хэмжээний хэмнэлтийн горимд шилжиж бүхий л нөөц бололцоогоо дайчлан ажиллаж 2014 оны зорилтыг хангалттай биелүүллээ гэж үзэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

КОМПАНИЙН 2015 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ЗОРИЛТ

2015 оныг компани хөдөлмөр, аюулгүй ажиллагаа, ажлын чанарыг дээшлүүлэх жил болгон зарлаж байна. Компани 2015 онд бие даан болон түншлэлээр 60 орчим тэрбум төгрөгийн сонгон шалгаруулалтанд оролцохоор одоогийн байдлаар төлөвлөөд байна. Энд улсын төсөв болон нийслэлийн төсөв, Чингис, самуурай бондын хөрөнгө оруулалтаар хэрэгжих уул уурхайн салбарт амжилттай хэрэгжиж байгаа Оюу толгой, Таван толгой, Эрдэнэт үйлдвэрээс хэрэгжүүлэх төслүүд багтаж байна. Оролцохоор төлөвлөж байгаа тендерүүдийг хавсралт 2-оос харна уу.

2011 оноос олон улсын чанартай хурдны зам барих төслийг хэрэгжүүлэх, томоохон бүтээн байгуулалтанд хүчээ нэгтгэн оролцох зорилгоор үндэсний замын болон барилгын томоохон компаниудтай хамтран /Нарны зам ХХК, Магнай трейд ХХК, Чингис глоб Магистрал ХХК/ консерциум байгуулаад байна. Энэ групп одоогийн байдлаар Алтанбулаг-Замын үүд чиглэлийн 997 км хурдны зам барих төслийн концесс олгох урьдчилсан болон 2 шатны шалгаруулалтад оролцож ялалт байгуулан 2013 оны 03 сарын 18-ны өдөр концесс хэрэгжүүлэх гэрээг Чингис групп Монгол улсын засгийн газартай байгуулсаныг та бүхэн мэдэж байгаа. Чингис группын хэрэгжүүлэх “Талын зам” төсөл түүний дотор Алтанбулаг-Улаанбаатар-Замын Үүд чиглэлийн 997 км хурдны авто зам барих ажилд ОХУ-ын Партнёр ООК-тай хамтран Хос мөнгөн зам ХХК-г байгуулан ажиллаж байна.

Шинэ боловсон хүчнээр цус сэлбэх, шалгарсан тендерүүдээс шалтгаалан мэргэжлийн 5 хүртэлх тооны инженерүүдийг бэлтгэн авах шаардлагатай байна. Шинээр орох инженер, техникийн ажилтануудтай гэрээ байгуулан, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тодорхой хэмжээний хөрөнгө гаргах шаардлагатай.

2015 онд оролцох тендерүүдийн баталгаануудыг гаргахад хөрөнгийн эх үүсвэр шаардлагатай болох бөгөөд бид эхний ээлжинд хамтран ажиллаж байгаа Хаан банктай 2013, 2014 онд байгуулсан 4,5 тэрбум төгрөгийн баталгааны эх үүсвэрийн гэрээг сунгах, эх үүсвэрийн хэмжээг нэмэгдүүлэх хүсэлтэй илэрхийлээд байна.

2013 оноос эхлэн улсын төсөв болон бусад санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслүүдийн хэмжээ, үнийн дүн нь өндөр болж байгаатай холбогдож барилга угсралтын ажлыг гүйцэтгэх техник, тоног төхөөрөмжийн хүчин чадал, тоо ширхэг хүрэлцэхгүй болж байна. Иймд бид үе шаттайгаар техникийн шинэчлэл хийх, чухал хэрэгцээтэй гаднаас түрээсээр хэрэглэхэд өндөр төлбөртэй байгаа техникүүдийг төлбөрийн боломжит хувилбараар худалдан авах шаардлагатай байна. Одоо компанид хэрэглэгдэж байгаа зарим хүнд машин механизмууд нь 10-15 жил ашиглагдаж, цаашид эвдрэл гэмтэл их гарах болсоноос техникийн хүчээр хийгдэх барилга угсралтын ажил зарим тохиолдолд саатахад хүрээд байна. Иймд техник технологийн шинэчлэлийг барилга угсралтын ажил гүйцэтгэлтэй уялдуулан санхүүгийн боломжит хэлбэрээр хийх төлөвлөгөөтэй байна. Юуны өмнө дараах техник тоног төхөөрөмжийг худалдан авах шаардлагатай байна. Хавсралт 3-аас харна уу.


Компани тендер баримжаатай байх нь ашиг орлогын хувьд хангалттай бус байгаа томоохон бүтээн байгуулалтын ажлыг концессын хэлбэрээр гүйцэтгэхэд санхүүгийн хувьд хүрэлцээгүй байна. Иймд компанийн эзэмшлийн хотын А зэрэглэлийн бүсэд байгаа /одоо оффис байгаа/ газрын үр өгөөжийг дээшлүүлэх, боломжит ашгийг хүртэх зорилгоор 104 айлын орон сууцны барилгыг барихаар архитектурын дүгнэлтийг гаргуулж хотын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд оруулж батлуулахаар хүсэлтэй илэрхийлээд байна. Тухайн төсөлд 10 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт шаардагдахаар эхний тооцоо гаргаад байна. Зургийн ажил дуусч төсөв гарсан үед эцсийн төсөв гарах тул тухайн үед нь Төлөөлөн Удирдах Зөвлөлд оруулан батлуулах нь зүйтэй байх гэж бодож байна.

Мөн Полисан ХХК-тай хамтран урьдчилсан дулаалгатай ган болон хуванцар хоолойн үйлдвэрлэл Ф100-аас Ф1200мм-ийн диаметртэй ган труба үйлдвэрлэх /бэлэн бэлдцийг импортлох/ төслийг хэрэгжүүлэхээр техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж байна. Тухайн төслүүд нь Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлэх 888 төслийн нэн даруй хэрэгжүүлэх жагсаалтанд багтсан бөгөөд БХБЯ, ЭХЯ, АУЯ-аас дэмжлэг

аваад байна. Тухайн төслүүдэд 21 тэрбум төгрөг шаардлагатай бөгөөд үүнээс 30 хувийг өөрийн хөрөнгөөр үлдэгдэл 70 хувийг зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөж байна.

Урд онуудад гүйцэтгэсэн боловч тодорхой шалтгаануудын улмаас улсын комисст хүлээлгэж өгөөгүй, дуусгаагүй барилга угсралтын ажлуудыг энэ ондоо багтаан 100 хувь ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх зорилт тавин ажиллана.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



2015 онд оролцох тендерийн жагсаалт /сая төгрөгөөр/

№	Хөрөнгө оруулалт	Тендерийн нэр	Дүн	Огноо	Баталгаанууд		
					Тендер	Гүйцэтгэл	Урьдчилгаа
1	Нийслэлийн төсөв	Ногоон зорь орчмын орон сууцны хорооллын цэвэр усны шугамын ажил	900,0	2015 он	9,0	45,0	270,0
2	Улсын төсөв	Налайх дүүргийн шугам сүлжээний ажил	1200,0	2015 он	12,0	60,0	360,0
3	Улсын төсөв	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн инженерийн шугам сүлжээ	3500,0	2015 он	35,0	175,0	1050,0
4	Хөгжлийн банк	Яармаг хорооллын цэвэр усны гол шугам сүлжээ /15км/	4600,0	2015 он	46,0	230,0	1380,0
5	Эрдэнэт ТӨҮГ	Эрдэнэт ТӨҮГ-ын Ф1000-ийн бкм инженерийн шугам сүлжээний ажил	13650,0	2015-2016 он	136,5	682,5	1755,0
6	Эрдэнэт ТӨҮГ	Эрдэнэт ТӨҮГ-ын Ф200-ийн /61км/ хэсэгчилсэн инженерийн шугам сүлжээний ажил	5850,0	2015 он	58,50	292,5	1755,0
7	Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар	Баянхошууны ариутгах татуургын 2-р хэсгийн зөөлөн ширмэн (ЗШ) хоолой бүхий 2250 метр ариутгах татуургын шугамын барилгын ажил	4644,0	2015	46,44	232,2	1393,2
8	Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар	Сэлбийн ариутгах татуургын зөөлөн ширмэн (ЗШ) хоолой бүхий ариутгах татуургын шугамын барилгын ажил	5000,0	2015	50,0	250,0	1500,0
9	Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар	Баянхошууны ариутгах татуургын 1-р хэсгийн зөөлөн ширмэн (ЗШ) хоолой бүхий 4116 метр ариутгах татуургын шугамын барилгын ажил	6456,0	2015	64,56	322,8	1936,8
10	Оюу толгой	“Оюу толгой” шугам сүлжээний ажил	6500,0	2015	65,0	325,0	1950,0
11	Бусад	Бусад төсөл, арга хэмжээ	10000,0	2015-2016	100,0	500,0	3000,0
	Нийт дүн		62300,0		623,0	3115,0	18690,0

2015 онд худалдан авах техник тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Техник, тоног төхөөрөмжийн нэр, марк	Тоо ширхэг	Үнэ /төг/	Худалдан авах хугацаа	Тайлбар
1	Ковш 30	1	90 000 000	2015 он	Шинэ буюу шинэвтэр
2	Трэйллэр чирэгч толгой Howo	1	80 000 000	2015 он	Шинэ буюу шинэвтэр
3	Тог үүсгүүр 380W	2	30 000 000	2015 оны 06 сар	Япон буюу Солонгос улсад үйлдвэрлэсэн шинэ
4	Компрессор	1	20 000 000	2015 оны 06 сар	Япон буюу Солонгос улсад үйлдвэрлэсэн шинэ
5	Гагнуурын аппарат 380W	3	21 000 000	2015 оны 05 сар	Япон буюу Солонгос улсад үйлдвэрлэсэн шинэ
6	Хуванцарын гагнуур /Ф200-Ф400/	4	40 000 000	2015 оны 05 сар	Хятад
	Нийт дүн		281 000 000		